

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАР ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХ, ХАМГААЛЛЫН” ЧИГЛЭЛЭЭР
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

/2025 оны жилийн эцсийн байдлаар/

Орхон аймаг

2025.12.12

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2025 онд Хүрэх түвшин	Төсөв		Хүрсэн түвшин (биелэлт)	Хэрэгжилтийн хувь
			Зарцуулсан төсөв	Эх үүсвэр хаанаас		
НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ						
1.	Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын чиглэлээр мөрдөгдөж буй хууль эрх зүйг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих, арга зүйгээр хангах	Хэрэгжилтийн хувь-80	-	-	Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг гарган, батлуулж хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. - Аймгийн хэмжээнд Нялхсын эндэгдлийг бууруулах 3 бүлэг,13 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг батлуулан хэрэгжилт 90.2%-тай байна. -Эх, хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт,эмнэлзүйн удирдамж,тушаал зааврын хэрэгжилт, цаг үеийн болон хариу арга хэмжээ, зохицуулалтын талаар сум, өрхийн эмч нарт 9 удаа мэдээлэл, чиглэл өгч, эх, хүүхдийн тусламж үйлчилгээнд 3 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгч ажилласан. - Тайлант хугацаанд Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам, хүүхэд хамгааллын тухай хууль болон хүүхэд хамгааллын талаар гарсан эрх зүйн баримт бичгүүдийн талаар 2 удаагийн чиглэл, мэдээлэл сургалтыг зохион байгуулж, тус сургалтад 95 сум, өрхийн эрүүл мэндийн төв эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтныг хамруулж чадавхжуулан арга зүйгээр хангаж ажилласан.	90
2.	Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр мэдээллийн урсгал, мэдээлэл солилцоог сайжруулан хариу арга хэмжээг салбар дундын байгууллагуудтай шуурхай авч хэрэгжүүлэх	Салбар дундын уялдаа холбоо сайжирсан байна.	-	-	Баян-Өндөр сумын хүүхэд хамгааллын хамтарсан баг 4 удаа хуралдаж, эцэг эх нь архины хамааралтай, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 6 тохиолдлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүний эрхийн тухай ярилцъя хурал, уулзалтад хамтран оролцож, хүүхдийн тэргүүлэх өвчлөл, хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр тулгамдсан асуудлуудыг хэлэлцсэн. Өсвөр үеийн кабинетад насанд хүрээгүй өсвөр насны 3 жирэмсний тохиолдлын мэдээллийг шуурхай солилцож хурлаар хэлэлцүүлэн харьяаллын өрхийн эмч болон БОЭТ-н төрөх тасаг БЗДХ-н кабинет, сэтгэлзүйч, хүүхэд хамгааллын багтай хамтран тусламж үйлчилгээ үзүүлсэн. “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” сургалт хэлэлцүүлгийг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Боловсролын газар, Цагдаагийн газартай хамтран зохион байгуулж салбар дундын уялдаа холбоог сайжруулан ажилласан. Тус хэлэлцүүлэгт ЕБС-ийн ахлах ангийн 120 сурагч хамрагдаж тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, эрүүл мэндийн боловсролыг олон талт байдлаар	70

					олгож хамтран ажилласан.	
3.	Хүүхэд хамгааллын багийн гишүүдийг чадавхжуулах, үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллах	Сургалтын тоо-1	-	-	Баян-Өндөр сум нь хамтарсан 26 багтай бөгөөд нийт салбар дундын 224 гишүүнтэй. Хамтарсан багийн гишүүдийн 28 буюу 12.5 хувьд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нар хамтран ажиллаж, эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн, салбар дундын уялдаа холбоог хангаж байна. Анхан шатны тусламж үйлчилгээнд өсвөр үеийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгын хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах, далд хүчирхийллийг илрүүлэх, эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын чиглэлээр ажлын байранд чадавхжуулах 1 удаагийн сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн 7 төвийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, хамтарсан багаар ажиллах, мэдээллийг урсгалын дагуу шуурхай түгээх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, далд хүчирхийллийг илрүүлэх, таних, мэдээлэх, баримтжуулах талаар арга зүйн зөвлөмж өгч чадавхжуулсан.	90
4.	ЭМГ, БШУГ-тай хамтран хүүхдийн байгууллагад эрүүл ахуйн үнэлгээ хийж, хяналт тавих	Хүүхдийн байгууллага удад хийгдсэн эрүүл ахуйн үнэлгээний тоо-3	-	-	Тайлант хугацаанд Орхон аймагт нийт 24 ерөнхий боловсролын сургууль, 39 сургуулийн өмнөх боловсрол, 1 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв буюу нийт 64 боловсролын байгууллагад 36336 хүүхэд суралцаж байна. Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар нийт 44 боловсролын байгууллагыг хамруулсан. Хяналт шалгалтаар нийт 340 зөрчлийг илрүүлж, 173 зөрчилд улсын байцаагчийн 23 албан шаардлагыг хүргүүлж, 100 зөрчлийг газар дээр нь арилгуулж, нийт зөрчлийн 80%-ийг арилгуулж ажилласан байна.	100
5.	Хүүхэд, өсвөр үеийнхэнд хорт зуршлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	Хүүхдийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо 2	-	-	-Тамхины хор нөлөөний талаар 35 удаагийн сургалтад 20 сургууль болон Орхон МСҮТ-ийн оюутан, сурагчид, иргэд 10100 хүн хамрагдаж, 16 төрлийн 2408 тараах материал тараасан. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран ШШГГ-ын хяналтад байдаг 21 хүүхдэд Эрүүл бус хүнсний хэрэглээ, Өсвөр насныханд зонхилон тохиолдох хоол боловсруулах замын эмгэг, хорт зуршил сэдвийн хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан. “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” аян зохион байгуулагдаж нээлтийн арга хэмжээний сургалт хэлэлцүүлэгт Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 120 сурагчид хамрагдаж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, эрүүл мэндийн боловсролыг олон талт байдлаар олгосон. Тус аяны хүрээнд 4 сургуулийн 296 сурагчдад сэтгэл зүйн сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч ажилласан. 2 сумын 28 багийн нутаг дэвсгэрт Тамхи болон тамхин бүтээгдэхүүн худалдан борлуулдаг 57 дэлгүүрт хяналт хийж, зөвлөмж, уриалга хүргүүлсэн ба Жаргалант сумын ЕБС-ийн дунд, ахлах ангийн хүүхдүүдийн дунд электрон тамхины хэрэглээнд 7 удаа хяналт хийж, илрүүлэх, арилгах ажлыг зохион байгуулсан.	100

					Аймгийн хууль, эрх зүйн хэлтсийн “Хуулийн цаг” нэвтрүүлэгт Электрон тамхины хор хөнөөлийн чиглэлээр 2 эмч оролцож иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгосон. ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдад “Электрон болон бусад төрлийн тамхины хэрэглээ, биед үзүүлэх сөрөг нөлөөний талаар 8 удаагийн сургалтыг зохион байгуулж 529 сурагч эцэг эхийг хамруулан 142 гарын авлагыг түгээж мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. - Эрүүл мэндийн салбарын 10 пэйж хуудсаар өдөр бүр мэдээлэл оруулж иргэдэд түгээн ажилласан ба нийт давхардсан тоогоор 486 мэдээлэл оруулж, хандалтын тоо 107262 байна.	
6.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээг сайжруулах	Эрт үеийн нөхөн сэргээх, эмчилгээ үзүүлэх тусламж үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо -35	-	-	2025 оноос эхлэн АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран “Солонгон ертөнц” сэргээн засах клиник дэмжлэгт төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төсөл нь 17 сая төгрөгийн санхүүжилттэйгээр хэрэгжиж, СӨБ-ын 27 болон 7 дугаар цэцэрлэгийн тархины саа, саажилт, эпилепси гэсэн оноштой 15 хүүхдэд 3 сарын хугацаанд урт хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн. Төслийн хүрээнд нийт 1920 удаагийн сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн БОЭТ-ийн Сэргээн засах эмчилгээний тасагт 95 хүүхэд хамрагдаж, нийт 475 удаагийн богино хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. АЗДТГ-ын санхүүжилтээр Эрхэм нандин сувд ТББ-тай хамтран аутизм, тархины саа саажилт, уналт таталт, эпилепси, тархины усжилт зэрэг оноштой 34 хүүхдүүдийг ЭХЭМҮТ-д нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан. Тус үзлэгийг Гэмтэл согог судлалын үндэсний төвийн хүүхдийн гэмтлийн мэс заслын эмч, ШУГТЭ-ийн зүрхний мэс заслын эмч, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн сэтгэцийн 2 эмч, Эх нялхсын эрүүл мэндийн төвийн чих хамар хоолойн, сэргээн засах, дотор, нүд, уушги, бөөр, мэдрэл, үе мөч, зүрх судас, дотоод шүүрэл, хоол боловсруулах эмгэг зэрэг хүүхдийн нарийн мэргэжлийн 19 эмч нар үзлэгийг явуулж давхардсан тоогоор 172 удаагийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамрагдсан байна. - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өсөлт, хөгжлийг дэмжих, тэдгээрийн асаргаа, хүмүүжлийн онцлогийг ойлгуулах зорилгоор Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн (АШУҮИС) Сэргээн засах анагаах ухааны тэнхимтэй хамтран эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтаар хүүхдийн хөгжлийн онцлог, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн хөгжүүлэх арга зүй, хөдөлмөр засал, зөв байрлал, хооллолт болон булчин чангарлын менежментийн талаарх мэдээллийг 35 эцэг эх, асран хамгаалагч нарт түгээсэн. - Эрдэнэт сувиллын цогцолбор (ЭСЦ) нь сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй (СӨЭМТ) хамтран “Сэргээн засалт ба хөгжлийн бэрхшээл” сэдэвт өдөрлөгийг зохион байгуулж, 15 хүүхэд болон тэдний эцэг, эх, асран хамгаалагчид оролцсон. Энэ үеэр ЭСЦ-ын сэргээн засах багийн эмч нар хүүхдүүдэд эмчийн үзлэг,	100

					хөдөлгөөн засал болон бусад сэргээн засах эмчилгээний үйлчилгээг үзүүлсэн.	
7.	Нярайн тусламж үйлчилгээг сайжруулах, нярайн эмч нарыг тасралтгүй чадавхжуулах	Чадавхжуулах сургалтад хамрагдсан нярайн эмчийн тоо-5	-	-	- НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр АШУҮИС-ийн “Нярайн скринингийн салбар төв”-ийг БОЭТ-ийн нярайн тасагт байгуулан, төрсөн нярай бүрт 5 төрлийн эрт илрүүлэг нярайн скрининг оношилгоо хийгдэж байна. - “Нярайн цогц скрининг шинжилгээг нутагшуулах нь” эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг ЭМЯ, НҮБХС, Нярайн цогц скринингийн үндэсний багтай хамтран зохион байгуулж, Орхон, Булган, Сэлэнгэ, дархан-Уул, Төв нийт 5 аймгийн 6 эрүүл мэндийн байгууллагын 19 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан. НҮБХС, ЭМЯ-аас 14.5 сая төгрөгийн санхүүжилтээр нярайн эрт илрүүлэгт шаардлагатай тоног төхөөрөмжийг (хөдөлгөөнд тэсвэртэй пульскосиметр 17 ширхэг, арклайт 5 ширхэг) нярайн тасагт хүлээлгэн өгсөн. - Тайлант хугацаанд 1774 нярай төрсөн ба үүнээс түнхний үений эхо оношилгоонд 1771, сонсголын скринингэд 1111, нүдний угийн улаан рефлексийг 1772, бодисын солилцооны скринингэд 1347 нярайг хамруулсан. Сурфактант эмчилгээг амьсгал хямралын хам шинжтэй, дутуу төрсөн 26 нярайд хийж, 84.6 %-ийн үр дүн өгсөн нь өмнөх оны мөн үеэс 13.2%-р нэмэгдсэн. - БОЭТ, ЭХЭМҮТ-тэй хамтран нярайн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байранд чадавхжуулах, сэлгэн ажиллуулах хүрээнд БОЭТ-ийн нярайн тасгийн 4 эмч тус бүр 7 хоногоор, 4 сувилагчийг ажлын 2 өдрөөр ЭХЭМҮТ-ийн дутуу нярайн тасаг, эрчимт эмчилгээний тасагт дадлагажуулан дутуу болон хэт бага жинтэй нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний ур чадварыг нэмэгдүүлэн, туршлага судлуулан ажиллуулж, чадавхжуулсан. - ЭМЯ, ЭХЭМҮТ, ЭМГ-аас хүүхэд, нярайн тусламж үйлчилгээний чиглэлээр 10 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 44 хүүхэд, нярайн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулсан. - БОЭТ-ийн нярайн тасгийн эрхлэгч Узбекистан улсын Ташкент хотноо “Нярай, перинаталь эмнэлзүйн форум”-д, хүүхдийн тасгийн эрхлэгч Солонгос улсын Сөүл хотноо “Олон улсын мэдрэлийн эмч нарын конгресс”-т тус, тус оролцож, туршлага солилцож, хамтын ажиллагаа уялдаа холбоог нэмэгдүүлсэн.	100
ХОЁР. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ						
8.	Энэрэл төвийн хүүхдүүдийн бие бялдар, хоол тэжээл, далд өлсгөлөнг тандах, судлах, хариу арга хэмжээг авах, эрүүлжүүлэх	Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо-30	-	-	Энэрэл асрамжийн төвийн бүтэц орон тоонд 1 эмч орон тоогоор дагнан ажиллаж, тус төвийн 18 хүртэлх насны 54 хүүхдийг эрүүл мэндийн хяналтад авч, өдөр тутмын хооллолт, бие бялдарын өсөлт хөгжлийн байдалд үнэлгээ хийж, эрүүлжүүлэх, өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. “Энэрэл асрамжийн төвийн хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэг оношилгоог зохион байгуулан нийт 51 (94%) хүүхдийг чих хамар хоолой, нүдний эмч, хүүхдийн эмчийн үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулж шаардлагатай хүүхдийг эхо, зүрхний цахилгаан бичлэг, MRI, рентген оношилгоонд бүрэн хамруулсан. Тус үзлэг оношилгоогоор амны хөндийн өвчлөл 19%, чих хамар хоолойн өвчлөл 66%, өсөлт хөгжлийн хоцрогдол 15 хувьд нь илэрсэн бөгөөд өвчтэй илэрсэн 46	70

					хүүхдийг хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх зөвлөгөөг өгсөн байна.	
9.	Гэрээр хүмүүждэг, эмээ, өвөө дээрээ өсөж буй, асран хамгаалагч нь хөгжлийн бэрхшээлтэй, эцэг эх нь архины хамааралтай, үл хайхрах хүчирхийлэлд өртдөг бага насны хүүхдийг олж илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан зорилтот хүүхдийн тоо -30	-	-	Тайлант хугацаанд хамтарсан 26 багт нийт 251 кейс бүртгэгдэж үүнээс 203 тохиолдол дээр кейс менежментийн зарчим, алхмын дагуу хамтарсан багийн гишүүд уялдаа холбоотой ажиллаж шийдвэрлэсэн байна. Тайлант хугацаанд эцэг, эх асран хамгаалагчдын үл хайхрах, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 112 хүүхдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үйлчилгээ үзлэг, оношилгоонд хамруулсан байна. 8 өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар хамтарсан багийн 35 кейс тохиолдлын 74 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үүнээс 69 буюу 93.2% нь хүүхэд байна. Сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээ шаардлагатай 12 хүүхэд, эмэгтэйчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн байна. Гэрээр хүмүүждэг, эмээ, өвөө дээрээ өсөж буй, асран хамгаалагч нь хөгжлийн бэрхшээлтэй, эцэг эх нь архины хамааралтай зорилтот бүлгийн 3-16 насны 253 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулж, сэргээн засах эмчилгээнд 41 хүүхэд, өдрийн эмчилгээнд 100 хүүхдийг хамруулж, 30 хүүхэд витаминь багцыг олгож, гэртээ хүүхдээ хардаг зорилтот бүлгийн 13 ахмадад сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Гэрийн эргэлт, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоогоор эрсдэлт нөхцөлд буй эрх нь зөрчигдсөн 12 хүүхдийг илрүүлж мэдээлсэн.	90
10.	Өсвөр үеийн кабинетын үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж, нөхөн үржихүйн эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх тусламж үйлчилгээнд хяналт, үнэлгээг хийх,	Хяналтын тоо -1	-	-	Тайлант хугацаанд өсвөр үе, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чиглэлээр 3 албан тоот, 3 мэдээлэл, 2 удаа дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөмж өгсөн. - ЭМС-ын 2024 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/504 дугаар тушаалаар батлагдсан өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний журмыг 7 СӨЭМТ-ийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд танилцуулан ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж арга зүйн зөвлөмж өгч чадавхжуулсан. -ЭМГ-аас хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 354 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, дунд ангийн 70 багшийг хамруулж чадавхжуулсан. -Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх аяны хүрээнд ЭМ-ийн олон талт боловсрол олгох сургалтыг 1-12 дугаар ангийн 150 хүүхдэд зохион байгуулж, хүүхдийн аюулгүй тусламжийг дэмжих, аюулгүй байдлыг хангах постер мэдээлэл зөвлөмжийг 17 сургуулийн 586 сурган хүмүүжүүлэгч, 2909 сурагч, эцэг, эх асран хамгаалагчдад түгээсэн. -Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр БГ,ХГБХГ,ЦГ-тай хамтран “Өсвөр үеийнхнийг ойлгоё, сонсьё” аяныг зохион байгуулж, 6 төрлийн үйл ажиллагаа, 69 удаагийн сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэг, 16 удаагийн өдөрлөгт 19 сургуулийн 5-12 дугаар ангийн 3013 хүүхдэд зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөмж бүхий 2-5 төрлийн 3155 гарын авлагыг түгээж ЭМБ-ыг олон талт байдлаар олгож, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж ажилласан.	70

					-Өсвөр насны охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг зохион байгуулж, 552 охидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан 33 хүүхдийг эмчийн хяналтад авсан. -“Өсвөр насны охид хөвгүүдийн нөхөн үржихүйн онцлог, эрүүл ахуй, хорт зуршил ба эрүүл мэнд сэдвүүдийн хүрээнд СӨЭМТ-ийн харьяа ЕБ-ын 13 сургуулийн 7-12 дугаар ангийн 3369 хүүхдэд 19 удаагийн сургалтаар НҮЭМБ олгож, 2322 гарын авлага түгээж, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. ЭМГ-ын цахим хуудсаар хүүхэд, өсвөр үеийн чиглэлээр 41 постер, 10 видео шторк нийт 51 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 126762 иргэнд түгээсэн.	
11.	Хүүхдийн сувилал,ЭМБ-уудын сэргээн засах тусламж үйлчилгээний хүртээмжид үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллах	Хүүхдийн сувиллын тусламж, үйлчилгээнд хийгдсэн хяналт, зөвлөмжийн тоо-1	-	-	Эрүүл мэндийн байгууллагуудын Сэргээн засах тусламж үйлчилгээнд хийгдсэн дэмжлэгт хяналтаар хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангалт, чанарын үнэлгээ 89 хувьтай байна. -БОЭТ-ийн Сэргээн засах эмчилгээний тасагт 95 хүүхэд хамрагдаж, нийт 475 удаагийн богино хугацааны сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. - Тайлант хугацаанд зорилтот бүлгийн суурь өвчтэй сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нар, ус, агаар, эмчилгээний хоол, сүү цагаан идээ, аминдэмжүүлэлтэнд хамруулан эрүүлжүүлэн чийрэгжүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 30,0 сая төгрөгийг шийдвэрлэсэн. Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 5 хүртэл насны суурь өвчтэй хүүхдийн судалгааг сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн 272 хүүхдийн судалгааг гаргасан байна. Суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувиллыг гэрээгээр гүйцэтгүүлэхээр сонгон шалгаруулалт зарлагдаж, сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт ажиллаж хүүхдийн сувилалд хийсэн үнэлгээний дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн. Тус сонгон шалгаруулалтад Бүжинлхам хүүхдийн чийрэгжүүлэх гэр сувилалд 0-5 хүртэх насны суурь өвчтэй сульдаа, цус багадалт, хөгжлийн бэрхшээлтэй 100 хүүхдийг нар, ус, агаараар чийрэгжүүлсэн. Жин,өсөлтийн 1-р зэргийн хоцрогдолтой 65 хүүхэд, 2-р зэргийн 34 хүүхэд, 3-р зэргийн 4 хүүхдийн жингийн үзүүлэлт 200-500 гр нэмэгдэж 82,4 хувь нь жин, өсөлтийн үзүүлэлт дээшилсэн үр дүнтэй байна.	70
12.	Өсвөр насны хүүхэд, залуучуудын сэтгэцийн эрүүл мэнд, амиа хорлоход хүргэж буй хүчин зүйлийг тодорхойлох судалгаа хийх	Хийгдсэн судалгаа-1	-	-	Тайлант хугацаанд 2 удаагийн судалгааны ажил зохион байгуулж ажиллаж байна. Үүнд: - ЕБ-ын 20-р сургуулийн 9-11 дүгээр ангийн 310 хүүхдийг хамруулан “Өсвөр насны сурагчдын сэтгэл гутрал, өөртөө итгэх итгэл, стрессийн түвшин болон цахим хэрэглээний” байдлыг судалсан. Тус судалгааны үр дүнд судалгаанд оролцогчдын найман сурагч тутмын тав нь өөртөө итгэлтэй, найман сурагч тутмын гурав нь өөртөө эргэлздэг, найман сурагч тутмын дөрөв нь сэтгэл гутралын дунд ба дундаас дээгүүр түвшинд байна. Хойд эцэг эхтэйгээ амьдардаг сурагчид төрсөн эцэг эхтэйгээ амьдардаг сурагчдаас илүү сэтгэл	70

					гутралд өртөх магадлал өндөр байна. Судалгааны үр дүнгээс харахад найман хүүхэд тутмын 6 нь цахим орчныг идэвхтэй ашигладаг ба цахим хэрэглээний хамааралд өртөх эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан байна. - Сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, стрессийг илрүүлэх асуумж (DASS-21) Depression anxiety stress scale (DASS-21) асуумжийн DASS-D, DASS-A, DASS-S гэсэн 3 хэмжүүр тус бүр нь 7 асуултаас бүрддэг ба тус асуумжаар Цагаан тоосны бүсэд оршин суудаг иргэдээс түүврийн аргаар судалгаа авч авч ажиллалаа. Тус судалгаанд 17-65 насны 486 хүн хамрагдсан. Үнэлгээгээр сэтгэл гутрал, сэтгэл түгшилт, стресс хэвийн үнэлэгдсэн 290 хүн байсан. <u>DASS-D</u> буюу Сэтгэл гутрал хөнгөн хэлбэрийн n-22, дунд зэрэг n-18, хүндэвтэр n-5, хүнд n-6 хүн, <u>DASS-A</u> буюу Сэтгэл түгшилт хөнгөн хэлбэрийн n-34, дунд зэрэг n-21, хүндэвтэр n-22, хүнд n-24 хүн, <u>DASS-S</u> буюу стресс хөнгөн хэлбэрийн n-8, дунд зэрэг n-17, хүндэвтэр n-11, хүнд n-8 хүн байсан тул 196 хүнд ганцаарчилсан зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд Сэтгэцийн эмчид холбон зуучилж эмийн эмчилгээ зөвлөж ажилласан.	
13.	Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай хүүхдийг илрүүлэх, үнэлэх, ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш нарыг чадавхжуулах	Сургалтад хамрагдсан нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багшийн тоо 20	-	-	Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын 24 сургуулийн 29 нийгмийн ажилтан, 22 сэтгэлзүйч ажиллаж байна. -Хүүхдийн далд хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг илрүүлэх, баримтжуулах, хамгаалах үйлчилгээ үзүүлэх, сургалтыг 1 удаа зохион байгуулж 51 өрхийн эмч, ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтныг хамруулсан. - БГ-тай хамтран "Сайн туршлага" түгээн дэлгэрүүлэх сургалтын хүрээнд “Өсвөр үеийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох” сургалтыг зохион байгуулж анги удирдсан 70 багшийг хамруулж, өсвөр үеийнхний эрүүл мэнд, анхаарах асуудлууд болон нөхөн үржихүй, бэлгийн боловсролын талаар мэдлэг олгож тэдний эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. -Баянцагаан багийн хамтарсан багтай хамтран “Анзааръя-Анхааръя” аяны хүрээнд “Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж ЕБС-ийн дунд болон ахлах ангийн сурагчдын 100 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулан өсвөр насны хүүхдийн сэтгэлзүйн чиглэлээр эцэг эхийн мэдлэг боловсролыг сайжруулсан. -Сэтгэцийн эрүүл мэндийн Дэлхийн өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан “Гамшгийн үеийн сэтгэл зүй”, “Уй гашууг даван туулах нь”, “Стресс менежмент” сургалтад сэтгэл зүйч, нийгмийн ажилтан эмч нар нийт 78 мэргэжилтнийг хамруулсан. Ойлгоё-Хүндэлье”, “Сэтгэл эдгэрдэг” сэтгэл зүйн сургалтуудыг “Сэтгэл зүйн цогц боловсролын төв”-тэй хамтран зохион байгуулж 50 иргэн буюу 25 хосыг хамруулж сэтгэлзүйн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.	70
14.	Хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Дохионы	-	-	Дохионы хэлний сургалтыг үе шаттай зохион байгуулахаар төлөвлөн тайлант	100

	үзүүлдэг, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, угтах ажилтнуудыг дохионы хэлмэрчээр сургаж бэлтгэх	хэлмэрчийн сургалтад хамрагдсан хүний тоо-30			хугацаанд эрүүл мэндийн 14 байгууллагын 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд “Дохионы хэлний дунд шатны” сургалтад хамрагдан зорилтот бүлгийн иргэдэд хүрэх тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.	
15.	Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн түвшинд хүүхдэд үзүүлэх “Гэрийн эргэлт”-ийг эх, хүүхдийн эрүүл мэнд, хүүхдийн өсөлт, хөгжил, хамгаалалд чиглэсэн цогц үйлчилгээ хэлбэрээр олон нийтийн оролцоонд түшиглэн зохион байгуулах	Гэрийн эргэлийн хувь-15%	-	-	Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор БОЭТөвд нэмэлтээр 140 хүртэлх орыг дэлгэн хүүхдийн хүлээн авах хэсгийн ачааллыг бууруулах хүрээнд, хүүхдийн хүлээн авах хэсэгт 1 эмч, 1 сувилагчийг нэмэлтээр ажиллуулж, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. Анхан шатны эрүүл мэндийн төвүүдийг уртасгасан цагаар ажиллуулан, 5 хүртэлх насны хүүхдийн тусламж үйлчилгээг гэрийн эргэлтээр үзүүлэн ажиллаж байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 5 хүртэл насны хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл мэндийн байдал, идэвхтэй хяналт, гэрийн эргэлт, ХӨЦМ, MNS:5292:2017 стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийхэд MNS:5292:2017 стандартын хэрэгжилт 95% байна. СӨЭМТ-үүдэд 0-1 хүртэлх насны хүүхдийн идэвхтэй хяналтад хамрагдалт 94,3% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар нэмэгдсэн байна. Тайлант хугацаанд ӨЭМТ-үүд 0-1 хүртэлх насны 1854 хүүхдийг давхардсан тоогоор 25105 удаа гэрээр эргэж тусламж үйлчилгээ үзүүлэн ажилласан байна. - СӨЭМТ-үүдэд тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтад давхардсан тоогоор 78145 хүүхэд хамрагдсанаас 0.14 хувь нь туранхай, 0.15 хувь нь тураалтай, 0.28 хувь нь өсөлтийн хоцрогдолтой илэрсэн байна. - Эхний 11 сарын байдлаар сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд гэрийн эргэлтийн үзлэг 109869 хийгдэж, нийт үзлэгт эзлэх хувь 30.5% байгаа нь өмнөх оны мөн үеэс гэрийн эргэлт 1.4 хувиар буурсан байна. - Нярайн тусламж, үйлчилгээ, гэрийн эргэлтийг сайжруулах, “Хүүхдийн өвчний шинэчилсэн цогц менежмент”, эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, бага насны хүүхдийн өсөлтийг үнэлэх, хянах мэдлэг сэргээх, эмнэлзүйн удирдамжийн сургалтыг 5 удаа давхардсан тоогоор 149 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулж, чадавхжуулсан.	90
16.	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд бага насны хүүхдийн хөгжлийг хянах, өсөлт, хөгжлийн хоцролтыг эрт илрүүлэх үзлэгийг тогтмол зохион байгуулж, хөгжлийн хоцрогдолтой,	Олон нийтийн оролцоонд түшиглэн зохион байгуулсан үйл	-	-	- Хүүхдийн тусламж, үйлчилгээнд бага насны хүүхдийн хөгжлийг хянах, өсөлт, хөгжлийн хоцролтыг эрт илрүүлэх 9,18,36 сартай хүүхдийн цогц үзлэгийг тогтмол, тасралтгүй зохион байгуулж байна. 9,18,36 сартай хүүхдийн цогц үзлэгт 2284 хүүхдийг хамруулснаас 79 хүүхдэд хөгжлийн хоцрогдлыг илрүүлж лавлагаа шатлалд илгээж, хяналтад авсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлж, бусдын адил эрхээ эдлэх, нийгэм дэх оролцоог нэмэгдүүлж, тэдний боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор аймгийн Засаг даргын 2025 оны А/347 дугаар захирамжийн дагуу "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн	70

	эрсдэлтэй хүүхдэд зориулсан тусгай дэмжлэг, эрт үеийн оролцооны хөтөлбөрийг олон нийтийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлэх	ажиллагааны тоо-2			эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс" байгуулагдан үйл ажиллагаа нь тогтмолжсон. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс тайлант хугацаанд 21 удаа хуралдаж нийт 391 хүүхдэд комиссын хурлаар орсон байна. Үүнээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд 168, боловсролд 55, сунгалт 89, цуцлагдсан 38, шинээр орсон 69, буцаагдсан 28, бусад 112 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлөөс салбар зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах 3 удаагийн цахим сургалтад бүх гишүүд хамрагдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн өсөлт, хөгжлийг дэмжих, тэдгээрийн асаргаа, хүмүүжлийн онцлогийг ойлгуулах зорилгоор Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн (АШУҮИС) Сэргээн засах анагаах ухааны тэнхимтэй хамтран эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтаар хүүхдийн хөгжлийн онцлог, аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийн хөгжүүлэх арга зүй, хөдөлмөр засал, зөв байрлал, хооллолт болон булчин чангарлын менежментийн талаарх мэдээллийг 35 эцэг эх, асран хамгаалагч нарт хүргэсэн.	
17.	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтныг нярайн эрт үеийн оношилгоо хүүхдийн цогц хөгжлийн үзүүлэлтийг хянах арга зүйд сургах, чадавхжуулах	Сургалт хамрагдсан анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтны тоо-55	-	-	- Хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээний чиглэлээр танхимын 10 сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэгт 354, ЭХЭМҮТ-ээс зохион байгуулсан 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн өнөөгийн байдал, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах 6 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 63 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж, мэдлэг ур, чадвараа нэмэгдүүлсэн. Үүнд: - Бага насны хүүхдийг ахуйн болон гэнэтийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 50 эмчийг хамруулж чадавхжуулсан. "Хүүхдийн өвчний шинэчилсэн цогц менежмент", эхийн сүүгээр хооллолтыг дэмжих, бага насны хүүхдийн өсөлтийг үнэлэх, хянах мэдлэг сэргээх, эмнэлзүйн удирдамжийн сургалтыг 4 удаа давхардсан тоогоор 125 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулсан. - Төрөх үеийн ТҮ, нярай, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах хүрээнд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарыг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулж 49 эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлсэн. "Нярайн цогц скрининг шинжилгээг нутагшуулах нь" нярайн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг ЭМЯ, НҮБХС-тай хамтран зохион байгуулж, Орхон, Булган, Сэлэнгэ, дархан-Уул, Төв нийт 5 аймгийн 6 эрүүл мэндийн байгууллагын 19 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан.	100

					Өсвөр үеийн эрүүл мэндийн чиг баримжаа олгох сургалтыг 2 удаа, эх, нярайн тусламж үйлчилгээг сайжруулах салбар дундын хэлэлцүүлгийг 1 удаа зохион байгуулж нийт 113 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж чадавхжуулан, зөвлөмж, чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	
18.	Хүүхэд бүрийн эрүүл мэнд хөгжлийн цогц хяналтыг 9, 18, 36, 60 сартайд тасралтгүй хийж, үр дүнг тооцох	Жил бүрийн хамрагдалтыг 0,5%-р нэмэгдүүлж ажилласан байна.	-	-	Хүүхдийн тусламж, үйлчилгээнд бага насны хүүхдийн хөгжлийг хянах, өсөлт, хөгжлийн хоцролтыг эрт илрүүлэх 9,18,36 сартай хүүхдийн цогц үзлэгийг тогтмол, тасралтгүй зохион байгуулж байна. 9,18,36 сартай хүүхдийн цогц үзлэгт 2284 хүүхдийг хамруулснаас 79 хүүхдэд хөгжлийн хоцрогдлыг илрүүлж лавлагаа шатлалд илгээж, хяналтад авсан байна.	70
19.	Хүүхдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт хийх, зөвлөмж хүргүүлэх	Хяналтад хамрагдсан эрүүл мэндийн байгууллагын тоо-10	-	-	Тайлант хугацаанд Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төвд тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хангалт, хүүхдийн үзлэг, гэрийн эргэлт, диспансерын идэвхтэй хяналт, томуу болон улаан бурхан өвчний үеийн хүүхдийн тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт 3 удаа хийж, зөвлөмж хүргүүлсэн. Эх, хүүхдэд нэг цэгээс тусламж үйлчилгээ үзүүлэх ээлтэй байдлыг эрүүл мэндийн байгууллагууд ханган ажиллаж байна. - Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын тусламж, үйлчилгээг сайжруулах аяны хүрээнд 8 байгууллагын 42 өрх хариуцсан эмч нараас онолын мэдлэг шалгах тест, халдварын сэргийлэлт хяналт, хүүхдийн үзлэг, жирэмсний эрсдэлийн үнэлгээ, зөвлөгөө өгөх 4 өртөөгөөр эмнэлзүйн ур чадварын үнэлгээг зохион байгуулсан. Ур чадварын үнэлгээний дундаж: 77% бөгөөд, хүүхдийн үзлэгийн өртөөний дунджаар 84% үнэлэгдсэн байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь эрүүл болон өвчтэй хүүхдийн үзлэг, өсөлт хөгжлийг үнэлэх өрөө, дархлаажуулалтын өрөө, ХӨЦМ-ийн чиглэлээр шингэн сэлбэх, утлага хийх цэг, хүүхэд хөхүүлэх хэсэг, эх хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох өрөөнүүдийг эх хүүхдэд ээлтэй байдлаар тохижуулан тусламж үйлчилгээ авах мэдээллийн урсгалыг олон нийтэд ил тод байршуулаад байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх багаж тоног төхөөрөмжийн хангалт 92,0%-тай байна. Keller Williams Mongolia нь Нийгмийн хариуцлагын хүрээнд 10 сая төгрөгийн санхүүжилтээр БОЭТ-ийн нярайн тасагт "Дутуу нярайн уушги тэлэх неопап аппаратаар хангаж, нярайн хүлээн авах өрөөг эх, хүүхдэд ээлтэй байдлаар тохижуулснаар нярайн тусламж үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн.	100
ГУРАВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ						
20.	"Түр хамгаалах байр"-аар үйлчлүүлсэн хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн нөхцөл байдалд эрсдэлийн	Шаардлагатай үйлчилгээнд холбон	-	-	Тайлант хугацаанд түр хамгаалах байранд 69 хүүхэд, 8 насанд хүрэгч буюу нийт 69 хүн жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний улмаас түр хамгаалах үйлчилгээнд хамрагдсан байна. Үүнээс 11 хүүхдэд шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж ажилласан байна.	70

	үнэлгээг хийж, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах	зуучилсан хүүхдийн тоо- 15				
21.	Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжихэд эцэг, эх асран хамгаалагчдыг чадавхжуулах, үйлчилгээг өргөжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах	Чадавхжуулах сургалтад хамрагдсан эцэг, эх асран хамгаалагчдын тоо-100	-	-	“Эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн Эрүүл эхээс - Эрүүл хүүхэд” уриатай "Амьдралын алтан 1000 хоног" сургалтыг “Тогтвортой хөгжил ирээдүй” төрийн бус байгууллагатай хамтран эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг 8 удаа зохион байгуулж 390 жирэмсэн эх, түүний гэр бүлийг хамруулж 2 төрлийн 395 ширхэг гарын авлагыг түгээж ажилласан. Тус сургалтаар Амьдралын эхний 1000 хоногийн хугацаанд хүүхдийн өсөлт, хөгжлийг дэмжих, хянах, эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргааны талаар эцэг, эх асран хамгаалагчдын эрүүл мэндийн боловсрол дээшилсэн. - Эрүүл эхээс - Эрүүл хүүхэд", "Амьдралын алтан 1000 хоног" сургалтыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх тасагт хэвтэн эмчлүүлж байгаа 50 ээжид биечлэн сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн боловсрол олгож, тэдний мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. - “Алтан 1000 хоног” нэртэй фэйсбүүк группыг нээж сургалтад хамрагдсан ээжүүдийг урьж оруулан ээжүүд болон тэдний гэр бүлийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгохоор нарийн мэргэжлийн эмч, сэтгэлзүйчийн ярилцлага, мэдээлэл зөвлөмж бүхий 6 төрлийн видеог бэлтгэж, байршуулан нийт 7690 иргэнд эрүүл мэндийн мэдээлэл түгээж ажилласан байна. - Өрхийн эрүүл мэндийн төвүүд “Ээжүүдийн клуб”-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, 6-10 төрлийн сэдвийн хүрээнд 31 удаагийн сургалтад давхардсан тоогоор 979 жирэмсэн болон хөхүүл эхчүүд, бага насны хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулан эрүүл мэндийн боловсрол олгож эх, хүүхдийн эрүүл мэнд, асаргаа, хоол тэжээл, хөх арчилгаа, жирэмсний хяналтын ач холбогдлын талаар эрүүл мэндийн боловсрол олгож, тэдний мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн.	100
22.	Осол, гэмтлээс сэргийлэх, нэн ялангуяа хүүхэд өндрөөс унаж гэмтэх, амь насаа алдахаас сэргийлсэн, цонхны хамгаалалт тор байрлуулах талаар зөвлөмж, мэдээллийг хүргэх	Осол, гэмтлээс сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо-2	-	-	ЭМГ-ын цахим хуудсаар хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр 7 зурган постер, 6 видео шторк нийт 13 мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд байршуулан сурталчилсан бөгөөд 23651 хүн үзсэн байна. Осол, гэмтлээс сэргийлэх сарын аяны хүрээнд 1 арга хэмжээ зохион байгуулж бага насны хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн 50 эмчийг хамруулсан байна. Угаарын хийн хордлого болон ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтыг 4 удаа зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн бага болон дунд ангийн 214 хүүхдийг хамруулж унах, хоолны хордлого, тогонд цохиулах, хурц иртэй зүйлс, түлэгдэх, галын аюулаас сэргийлэх замын хөдөлгөөнд болгоомжтой оролцох чиглэлээр зөвлөмж мэдээлэл өгсөн. Багийн хамтарсан	70

					багийн гишүүдтэй хамтран эрсдэл бүхий 120 өрхийн судалгааг гаргаж, эрсдэлийн үнэлгээ хийсэн бөгөөд үүнээс 18 өрхөд осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө зөвлөмж өгч 4 төрлийн 480 ширхэг гарын авлагыг түгээж ажилласан. - Бага насны хүүхдийг “Ахуйн осол гэмтлээс сэргийлье” сургалтыг 4 удаа зохион байгуулж 2-5-р ангийн 171 хүүхэд, бага ангийн 40 багшийг хамруулж тэдний мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн. - “Таны гэр аюулгүй орчин мөн үү?” сэдэвт сургалтуудыг 44 эмнэлгийн ажилчдад 2 удаа, 54 жирэмсэн эхчүүдэд 4 удаа, 6 асран хамгаалагч нарт 2 удаа сургалт зохион байгуулсан.	
23.	Гамшиг, онцгой байдлын үе, ган зуд, үер усны улмаас хохирсон өрхийн судалгаа, мэдээллийг нэгтгэн гаргаж, салбар дундын хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх	Тусламж үйлчилгээ үзүүлсэн хүний тоо-50	-	-	Өвөлжилтийн бэлэн байдлыг хангах болон нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах төлөвлөгөөний хүрээнд үйлчлэх хүрээний 35-120 км радиуст өвөлжиж байгаа 871 иргэн, эрсдэлт бүлгийн 301 иргэний судалгааг шинэчлэн тогтоосон, СӨЭМТ-ийн 6, БОЭТ-ийн 3 их эмчийг дайчлан хуваарийн дагуу 9 чиглэлд эмнэлгийн тусламж үйлчилгээг нийт 188 өрхийн 548 иргэнд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг явуулаар хүргэсэн. Нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө шаардлагатай 3 иргэнийг шаардлагатай лавлагаа шатлалын ЭМБ-т мэдээлж шилжүүлсэн	100
ДӨРӨВ. ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ АЮУЛГҮЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ						
24.	Ээжүүдийн клубын үйл ажиллагааг идэвхжүүлэх, эх, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа хамгааллын чиглэлээр эцэг, эх, асран хамгаалагчийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах	Сургалт, үйл ажиллагаан д хамрагдсан хүний тоо-350	-	-	Өрхийн эрүүл мэндийн төвүүд “Ээжүүдийн клуб”-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, 6-10 төрлийн сэдвийн хүрээнд 31 удаагийн сургалтад давхардсан тоогоор 979 жирэмсэн болон хөхүүл эхчүүд, бага насны хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулан эрүүл мэндийн боловсрол олгож эх, хүүхдийн эрүүл мэнд, асаргаа, хоол тэжээл, хөх арчилгаа, жирэмсний хяналтын ач холбогдлын талаар эрүүл мэндийн боловсрол олгож, тэдний мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. -Нийгмийн халамж нэн шаардлагатай жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд аймгийн ЗДТГ-ын 10 сая төгрөгний санхүүжилтээр 295 эмэгтэйд төмрийн бэлдмэл олгож, жирэмсэн, хөхүүл үеийн цус багадалт, үүнээс улбаатай сэргийлж болох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. - Эх, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн Эрүүл эхээс - Эрүүл хүүхэд" уриатай "Амьдралын алтан 1000 хоног" сургалтыг “Тогтвортой хөгжил ирээдүй” төрийн бус байгууллагатай хамтран эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг 8 удаа зохион байгуулж 390 жирэмсэн эх, түүний гэр бүлийг хамруулж 2 төрлийн 395 ширхэг гарын авлагыг түгээж ажилласан. Тус сургалтаар Амьдралын эхний 1000 хоногийн хугацаанд хүүхдийн өсөлт, хөгжлийг дэмжих, хянах, эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргааны	70

					талаар эцэг, эх асран хамгаалагчдын эрүүл мэндийн боловсрол дээшилсэн. - Эрүүл эхээс - Эрүүл хүүхэд", "Амьдралын алтан 1000 хоног" сургалтыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх тасагт хэвтэн эмчлүүлж байгаа 50 ээжид биечлэн сургалт зохион байгуулж, эрүүл мэндийн боловсрол олгож, тэдний мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. - ЭМГ-ын цахим хуудсаар хүүхдийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс сэргийлэх, томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх, эх, нярайн эрүүл мэндийн чиглэлээр 27 постер, 8 видео шторк, нийт 35 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 44072 эцэг, эх асран хамгаалагчдад түгээсэн байна. - Ээжүүдийн клубын хүрээнд бага насны хүүхдийг нэмэгдэл хоолонд хэрхэн оруулах, насанд нь тохирсон хооллолтын зөвлөгөөний 4 төрлийн рийл бичлэг хийж цахим хаягт байршуулж давхардсан тоогоор 1363 иргэнд түгээсэн. - "Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхам"-ын сургалтыг зохион байгуулж, БОЭТ-ийн төрөх, хүүхэд, нярайн тасгийн эмч, сувилагч, сум өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 25 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулж чадавхжуулсан.	
25.	Хүүхдийн байгууллагын орчинд хүүхдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хориглосон бүтээгдэхүүний худалдаа, борлуулалтад тавих хяналтыг сайжруулах	Хийгдсэн хяналтын тоо-1	-	-	Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/27 дугаартай "Ерөнхий боловсролын сургуулийн орчинд хүүхдэд худалдаалагдаж буй хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд ЕБС-ийн 150 метрт үйл ажиллагаа явуулж буй "Нүдэн хулан" ХХК, "Цагаан уул өгөөж" ХХК, "ЦСМБ" ХХК, "Ивээл хишиг" ХХК, "Сайхан уулын нуга" ХХК, "Хайрхан" ХХК, "Есөн-Эрдэнэ" ХХК, "Имж итгэл" ХХК-иудад хяналт шалгалт хийж, худалдааны газрын ажилчид холбогдох эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдаагүй 42,8 хувь, худалдааны ажлын байр нь эрүүл ахуйн нөхцөл шаардлага хангаагүй 28,5 хувь байна. Хаяг шошгогүй 2,552 кг хиамыг Хос гарьд ХХК-тай холбогдож буцаан татан авалт хийлгүүлж, шинжилгээний бичиг, гарал үүсэлгүй 228 ширхэг шарсан дүпү, 10 ширхэг напелион, 10 ширхэг оргилуун чикенийг хураан авч зөрчлийг газар дээр нь арилгуулж ажилласан.	70
26.	Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх, эрт илрүүлэх талаарх ойлголтыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээх	Олон нийтэд чиглэсэн мэдээллийг хүргэсэн байна.	-	-	Осол, гэмтлээс сэргийлэх сарын аяны хүрээнд 1 арга хэмжээ зохион байгуулж бага насны хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн 50 эмчийг хамруулсан байна. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах, осол гэмтлээс сэргийлэх талаар 1 удаагийн мэдээлэл, зөвлөгөөг 228 эцэг, эх асран хамгаалагчдад түгээсэн. Бага насны болон өсвөр насны хүүхдүүдийн дунд далд хүчирхийллийг илрүүлэх, таних, мэдээлэх, баримтжуулах сургалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран зохион байгуулж, хүчирхийллийг илрүүлэх талаар арга зүйн зөвлөмж мэдээлэл өгч, хүүхэд хамгааллын тухай хууль, эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал болон холбогдох журмыг танилцуулсан. Тус сургалтад Орхон аймгийн 17 Ерөнхий боловсролын сургуулийн 20 эмч, 19	70

					нийгмийн ажилтан, 7 ӨЭМТ-ийн 12 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, чадавхжуулсан. - ЭМГ-ын цахим хуудсаар хүүхдийг осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр 7 зурган постер, 6 видео шторк нийт 13 мэдээллийг олон нийтийн цахим сүлжээнд байршуулан сурталчилсан бөгөөд 23651 хүн үзсэн байна.	
27.	Хүүхдийн байгууллагуудад төлөвлөгөөт үзлэг шалгалтыг зохион байгуулж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх шаардлага зөвлөмж хүргүүлэх	Хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин бүрдүүлсэн байна.	-	-	Эрүүл мэндийн яамны салбарын улсын ерөнхий байцаагч, Боловсрол, шинжлэх ухааны яамны салбарын улсын ерөнхий байцаагчдын баталсан 03-00/02 дугаартай “Боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд Ерөнхий боловсролын Киришима, Ирээдүй одод, Уран эгшиг, 7, 13, 16, 18, 20 дугаар сургуулиуд, Баян-Өндөр, Яргуй эко-2, Унага, Тэмүүлэл, Бяцхан одод, Миний гэр, 4 дүгээр цэцэрлэгүүд, Хөдөө аж ахуйн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болох нийт 17 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. 10.6.1 кодтой “Цэцэрлэгийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн хувь 88,4, эрсдэл үүсэх магадлал 11,5 хувь буюу “Бага” эрсдэлтэй үнэлэгдсэн. 10.6.2 кодтой “Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөлийг шалгах хяналтын хуудас”-аар эрсдэлийг үнэлэхэд хууль сахин мөрдөлтийн хувь 74,6, эрсдэл үүсэх магадлал 25,2 хувь буюу “Бага” эрсдэлтэй үнэлэгдсэн. Тайлант хугацаанд нийт төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан нийт объектын хууль сахин мөрдөлтийн хувь 78,67, эрсдэл үүсэх магадлал 21,1 хувьтай үнэлэгдсэн байна. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 146 заалттай, 15 албан шаардлага, 10 заалттай 5 дүгнэлтийг хүргүүлсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шалгалтын явц 94.4 хувьтай. Энхжин цэцэрлэг 2025 оны 02 дугаар сараас үйл ажиллагаа явуулаагүй байна.	70
28.	Бага насны хүүхэдтэй ажилтныг дэмжих, ажлын цагийн болон “Хүүхэд асрах чөлөө”-ний уян хатан зохицуулалтыг хэрэгжүүлэх, эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх	Зохион байгуулсан арга хэмжээний тоо-2	-	-	Орхон аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын дэргэдэх 121 эцэг эхийн зөвлөл гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хөгжлийг дэмжих, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, байгууллагын дотоод журамд хүүхэд асрах чөлөө, хүүхдийн үйл ажиллагаанд оролцох өдрүүдэд зохицуулалт хийгдэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. 18 байгууллага хүүхдийн өрөөг бий болгож, 95 байгууллага хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэн ажиллаж байна. - Бага насны хүүхэдтэй ажилтныг дэмжих, ажлын цаг болон “Хүүхэд асрах чөлөө”-г уян хатан зохицуулалтаар шийдвэрлэх заалтыг байгууллагууд дотоод журамд тусган хэрэгжүүлж байна. -Орхон аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн хурлаар хагас жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж, томуу, томуу төст өвчин, Улаанбурхан өвчний тохиолдол нэмэгдэж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын амралт эхэлсэнтэй холбоотойгоор 2-6 насны хүүхдүүд эцэг эх, асран	100

					хамгаалагчид ажлын байдлаас шалтгаалан гэртээ харгалзах хүнгүй үлдэх, осол гэмтэлд өртөх эрсдэлтэй тул бага насны хүүхэдтэй ажилтныг дэмжих, цахимаар болон богиносгосон цагаар ажиллах уян хатан зохицуулалтыг хийж, хүүхэд өвдсөн тохиолдолд гэрээр болон эмнэлэгт асрахад цалинтай чөлөө олгож ажиллах тухай Засаг даргын чиглэлийг байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Эрүүл мэндийн газар хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажилладаг бөгөөд байгууллагад шинээр орсон албан хаагчид хүүхэд хамгааллын бодлого, ёс зүйн дүрмийг танилцуулж, арга зүйн зөвлөмж өгч ажиллаж байна. - МУ-ын ЗГ-ын 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 147 дугаар тогтоолыг Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй Бүсийн оношилгоо эмчилгээний төв, ор бүхий клиникүүд, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, эм холбоо, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. БОЭТ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс 15 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан албан хаагч томуу, томуу төст өвчнөөр өвчилсөн 6 хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, эсхүл гэрээр асрахаар ажлын тав хүртэлх хоногийн цалинтай чөлөөг авсан байна.	
29.	Хүүхдийн сэтгэл зүйг дэмжих, хүүхэдтэй тэгш харилцах, ялгаварлан гадуурхалтгүй үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын ээлтэй орчин бүрдүүлэх	Хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллагын тоо-10	-	-	Эх хүүхдэд нэг цэгээс тусламж үйлчилгээ үзүүлэх ээлтэй байдлыг эрүүл мэндийн байгууллагууд ханган ажиллаж байна. -Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх тасгийн хүлээн авах хэсэгт нярайн үзлэг оношилгооны өрөөг эх, хүүхдэд ээлтэй байдлаар тохижуулан нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. -Сум, өрхийн эрүүл мэндийн 8 төв нь эрүүл болон өвчтэй хүүхдийн үзлэг, өсөлт хөгжлийг үнэлэх өрөө, дархлаажуулалтын өрөө, ХӨЦМ-ийн чиглэлээр шингэн сэлбэх, утлага хийх цэг, хүүхэд хөхүүлэх хэсэг, эх хүүхдэд эрүүл мэндийн боловсрол олгох өрөөнүүдийг эх хүүхдэд ээлтэй байдлаар тохижуулан тусламж үйлчилгээ авах мэдээллийн урсгалыг олон нийтэд ил тод байршуулсан байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эх хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх багаж тоног төхөөрөмжийн хангалт 92,0%-тай байна. Тайлант хугацаанд жирэмсэн ээжүүдийн эрүүл мэнд аюулгүй байдлыг дэмжиж бүтэн биеийн массажны сандлыг ӨЭМТ-д шинээр нэвтрүүлж хүчилтөрөгчийн коктейль эмчилгээгээр жирэмсэн ээжүүддээ үйлчилж эх, хүүхдэд ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Ахлах ангийн сурагчдад “ЭЭЛТЭЙ ОРЧИН ЭРҮҮЛ ИРЭЭДҮЙ” сэдэвт хүүхдийн чуулга уулзалтыг зохион байгуулж, ЕБС-ийн ахлах, дунд ангийн 50 сурагчийг хамруулж, тэдний хэрэгцээ шаардлага, туламдсан асуудлыг тодорхойлж, багийн хүүхдийн манлайллыг нэмэгдүүлэх, оролцоог дэмжихэд хамтран ажилласан. ӨЭМТ нь харьяалал харгалзахгүй 189 сурагчийг эрүүл мэндийг үзлэг оношилгоонд хамруулж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэн 44 хүүхдэд томуугийн багц, 37 хүүхдэд аминдэмийн багцыг түгээж тэдний дархлааг дэмжиж зөвлөгөө өгч эрүүл мэндийн боловсрол олгосон.	70

30.	Архи, согтууруулах ундаа, мансууруулах бодисын талаарх эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Нөлөөлийн арга хэмжээний тоо-3	-	-	Тайлант хугацаанд нийт архи, согтууруулах ундаа, мансууруулах бодисын талаарх эрүүл мэндийн боловсрол олгох нөлөөллийн арга хэмжээг 4 удаа зохион байгуулж нийт 14155 хүнийг хамруулан, 4140 ширхэг гарын авлага түгээсэн байна. Үүнд: - Засгийн Газрын 2001 оны 224 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 494 дүгээр тушаалаар батлагдсан тэмдэглэлт өдрүүдийн нэг болох "Архидан согтуурахаас сэргийлэх 10 хоног"-ийн аяны хүрээнд Эрдэнэт үйлдвэрийн 1100 ажилтанд хорт зуршлаас татгалзах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, 1732 ширхэг гарын авлага тарааж ажилласан. - Архи бидний сонголт биш аяны хүрээнд “Архи тамхи шинэ үеийн сонголт биш”, “Хорт зуршил гэж юу? Хүүхдээ хэрхэн хамгаалах вэ? нөлөөллийн ажил, сургалт зохион байгуулж эрүүл мэнд, боловсролын байгууллагын 555 албан хаагчдыг хамруулсан ба архи, тамхины хор хөнөөлийн тухай 4 төрлийн тараах материалыг 218 иргэд түгээсэн. - Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас Улсын хэмжээнд зохион байгуулж буй “Анзаар-2” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Мансууруулах бодис, түүнээс урьдчилан сэргийлэх” сургалтыг 8 удаа зохион байгуулж 12 байгууллагын 2400 албан хаагчид болон сургуулийн ахлах ангийн хүүхдүүд, эцэг эхчүүдийг хамруулсан. - Тамхины хор нөлөөний талаар 35 удаагийн сургалтад 20 сургууль болон Орхон МСҮТ-ийн оюутан, сурагчид, иргэд 10100 хүн хамрагдаж, 16 төрлийн 2408 тараах материал тараасан. - Архины хамаарлын чиглэлээр ганцаарчилсан зөвлөгөөнд 214 хүн хамрагдсан байна.	70
Хэрэгжилтийн хувь-82,6/Тодорхой үр дүнд хүрсэн/						

ТАЙЛАН НЭГТГЭСЭН :ХӨҮТҮХМЭРГЭЖИЛТЭН

Д.ЦЭРЭНЛХАМ

ХЯНАСАН : ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ